



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Их эв намын Үндсэн дүрэм
(Шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Их эв намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Их эв намын дарга З.Бат-Отгон нь “Их эв намын Ээлжит бус III Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор намын үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг бүртгүүлэх тухай” өргөдлийг 233 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Бүртгэлийн албанаас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 2.5-д зааснаар сонсох ажиллагаа явуулахад 306 хуудас баримт бичиг, тайлбар, 1 ширхэг флаш нэмэлтээр хүлээн авсан.

Их эв намын Үндсэн дүрмийг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Их эв нам нь энэхүү хуульд заасан хугацааны дотор өөрийн намын Үндсэн дүрмийг шинэчлэн, хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д (цаашид “Хууль” гэх) заасан шаардлагад нийцүүлэн ирүүлсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Их эв намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг.Шийдвэр гаргах ажиллагааны тухайд:

Их эв намын Үндсэн дүрэм (2020 он)-ийн 6.2.4-т “Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол шийдвэр хуралдаанд оролцогчдын 50-иас дээш хувийн саналаар хүчин төгөлдөр болно”, 6.3.1-д “Намын их хурал нь 100-аас доошгүй төлөөлөгчөөс бүрдэнэ. Төлөөлөгчдийн 50 хүртэлх хувь нь эмэгтэй төлөөлөгч байна”, 6.4.4-т “Бага хурлын хуралдааны товыг уг хурал болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө намын дарга эсвэл удирдах зөвлөл зарлана. Бага хурлын ээлжит бус хурлын товд дээрх хугацаа хамаарахгүй”, 6.4.7.17-д “Намын ээлжит болон ээлжит бус их хурал хуралдуулах тов, хэлэлцэх асуудлыг тогтоох” бүрэн эрхийг намын Бага хурал хэрэгжүүлнэ гэж тус тус заажээ.

Өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудаас үзэхэд, Их эв намын Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор намын Ээлжит бус Бага хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр зарлан хуралдуулсан, тус Бага хурлын 03 дугаар тогтоолоор намын Ээлжит бус III Их хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр товлон зарлаж, 02 дугаар тогтоолоор 100-аас доошгүй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хуралдуулахаар шийдвэрлэж, хурлын товыг намын “ih ev nam” гэсэн цахим хуудсаар дамжуулан гишүүддээ нээлттэй түгээж, хуралд оролцох төлөөлөгчдийг бүртгэхэд 103 гишүүн саналаа илэрхийлжээ. Тухайн хуралд 83 гишүүн төлөөлөгчөөр оролцсноос 9 нь орон нутгийн төлөөлөл байх бөгөөд нийт төлөөлөгчдийн 43 буюу 51.8% нь эрэгтэй, 40 буюу 48.2% хувь нь эмэгтэй байна. Эдгээр гишүүдийг намын гишүүн, төлөөлөгч мөн эсэхийг шалгахад бүртгэлд нэр нь байхгүй 1, гишүүний үнэмлэхгүй 2 иргэн байгаа нь зөрчилтэй ч намын Ээлжит бус III Их хуралд төлөөлөгчөөр оролцохоор бүртгүүлсэн гишүүдийн олонх нь тухайн хуралд оролцсон байх тул дүрмийн дээрх заалтад нийцсэн гэж үзлээ.

Их эв намын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит бус III Их хурлаар намын Үндсэн дүрмийг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж, нууц санал хураалтаар Их хуралд оролцсон 83 төлөөлөгчийн 100%-ийн дэмжсэн саналаар Үндсэн дүрмийн 1, 3, 4, 5, 6, 7, 9, 10, 11 дүгээр бүлгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн болох нь өргөдөлд хавсарган ирүүлсэн Ээлжит бус III Их хурал болон Тооллогын комиссын тогтоол, хавсралт, хурлын тэмдэглэл, дүрс бичлэг, бусад баримтуудаар тогтоогдож байна.

Үүнээс гадна шүүхэд ирүүлсэн нэмэлт материалаас үзвэл 2024 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Их эв намын Ээлжит II Их хурлын 03 дугаар тогтоол, хавсралтаар Бага хурлын 30 гишүүний нэрсийг баталжээ.

Тус намын Үндсэн дүрмийн 6.4.8.1-д “Бага хурлын гишүүдийн 1/3-ээс доошгүйн шаардлагаар намын дарга эсвэл удирдах зөвлөл шаардсан хугацаанаас 21 хоногоос хэтрүүлэхгүйгээр зарлан хуралдуулах үүрэгтэй”, 6.7.2.2-т “Намын Бага хурлын хэлэлцэх асуудал, товыг зарлан хуралдуулах” эрхийг намын дарга хэрэгжүүлнэ гэж тус тус заасны дагуу Бага хурлын 15 гишүүнээс гаргасан шаардлагын дагуу намын дарга З.Бат-Отгоны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр шийдвэрээр намын Ээлжит бус II Бага хурлыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдуулахаар товлон зарлаж, хурлын товыг намын цахим хуудсаар дамжуулан Бага хурлын гишүүдэд мэдэгдсэн байх бөгөөд тухайн өдрийн Ээлжит бус II Бага хуралд 24 гишүүн оролцсон байна. Эдгээр гишүүдийг 2024 онд намын Их хурлаас сонгож баталсан намын Бага хурлын гишүүдийн нэрстэй тулган үзэхэд зөрчилтэй зүйл тогтоогдсонгүй.

Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж; намын Үндсэн дүрмийн 6.1-д “Намын бүх шатны байгууллага, гишүүд аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ цөөнхийн саналыг хүндэтгэлтэй сонсож, олонхын шийдвэр гарган, нийтээрээ дагаж мөрдөх нэгдмэл зарчмыг баримтална” гэж тус тус заажээ.

Их эв намын Ээлжит бус II Бага хурал 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Ээлжит бус III Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан” намын дүрмийн 3.5.5, 3.6, 3.8.2.2, 3.9.4, 6.1.2, 6.2.1, 6.4.2, 9.9.4 өөрчилж; 3.5.2, 6.1.6, 6.4.11.9, 6.6.1, 6.6.3.3, 9.3.3, 9.7.7, 9.9.1, 9.9.2, 9.9.4 дэх заалтуудыг нэмж оруулах саналыг тус хуралд оролцсон Бага хурлын гишүүд 100%-ийн саналаар дэмжсэн нь намын Үндсэн дүрэмд нийцсэн байна.

Хоёр. Намын дүрмийн шинэчилсэн найруулгын тухайд:

Аливаа улс төрийн нам нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес¹ дүгээр зүйлийн 1, 3-т заасны дагуу улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах бөгөөд намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх, мөн намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтоох; энэхүү хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 1.4-д нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах, намын үйл ажиллагаа дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүдэд нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан системд нийцсэн байх гол шалгуурыг баримтлахаар тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү үзэл санаанд нийцүүлэн Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлахдаа намын даргын эрх мэдлийг хэт өргөжүүлснээр тухайн намын дарга, үүсгэн байгуулагчаас шууд хараат, нэг хүн тойрсон бүлэглэл маягийн хэлбэртэй, нэг гэр бүл, нэг аж ахуйн нэгжийн нам байж болохгүй талаар санал дэвшүүлж, намын дотоод ардчиллын асуудлыг нарийвчлан

зохицуулж, хувийн болон бүлэглэлийн эрх ашиг идэвхэжсэн байгааг зогсоох, намын гишүүдийг аливаа шийдвэрт оролцуулдаг, хяналт тавьдаг, хариуцлага тооцдог, эрх зүйн орчныг бүрдүүлэх, намын гишүүдийн хяналтыг өргөжүүлэх, гишүүдийн оролцоог хангах, олонхын саналаар шийдвэрлэдэг зохион байгуулалттай байхаар хуулийн үзэл баримтлалд тусгасан.

Их эв нам нь хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн дүрмийг шинэчлэн баталсан, уг дүрэм нь Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэг. Намын бэлгэдэл, далбаа, албан хуудас, тамга, Гуравдугаар бүлэг. Намын гишүүнчлэл, Тавдугаар бүлэг. Орон нутаг дахь намын байгууллага, Зургадугаар бүлэг. Намын доторх эрх мэдлийн хуваарилалт, Долдугаар бүлэг. Намаас сонгуульд нэр дэвшигчийг тодруулах, Наймдугаар бүлэг. УИХ дахь Их эв намын бүлэг, Есдүгээр бүлэг. Намын хөрөнгө, орлого, санхүүжилт ба татварын журам, Аравдугаар бүлэг. Намыг өөрчлөн байгуулах, нэрээ өөрчлөх, Арваннэгдүгээр бүлэг. Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэсэн нийт 11 бүлгээс бүрджээ.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана” гээд 15.2.1-15.2.10-т намын дүрэмд тавигдах шаардлагыг тодорхойлжээ. Тодруулбал,

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам” гэж заасан, намын Үндсэн дүрмийн 6.1-д намын удирдах дээд байгууллага нь намын сонгуульт албан тушаалтнууд болон анхан, дунд шатны нэгжүүдээс сонгогдсон намын гишүүд, доод тал нь 100 төлөөлөгчдөөс бүрдэх Их хурал; 6.2-т төлөөллийн төв байгууллага нь Их хурлаас сонгогдох, суудлын тоо 30, бүрэн эрхийн хугацаа 4 жил байх Бага хурал; 6.4-т гүйцэтгэх төв байгууллага нь Бага хурлаас нууц саналтаар 4 жилийн хугацаагаар сонгогдсон 15 гишүүдээс бүрдэх Удирдах зөвлөл; 6.3-т хяналтын байгууллага нь Их хурлаас 4 жилийн хугацаатайгаар 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдах Хяналтын хороо; намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллага нь 7-11 гишүүнтэй монгол суу ухааны хүрээлэн; 6.6-д эдгээр байгууллагыг хуралдуулах, хурлын тов тогтоох, зар мэдэгдэх, хурал хүчин төгөлдөр болох нөхцөл, шийдвэр гаргах, санал хуралтын журам, мөн тус хурлын бүрэлдэхүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох болон бүрэлдэхүүнийг чөлөөлөх, огцруулах үндэслэл журмын талаар тус тус зохицуулжээ.

Түүнчлэн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг Үндсэн дүрмийн 3.1-д намын гишүүнээр элсэх; 3.2-т намын гишүүний эрх; 3.3-т намын гишүүний үүрэг, 3.5-т намын түдгэлзэх үндэслэл, гишүүнчлэл сэргэх, түүнийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, шийдвэр гаргах журам; 3.9-д намын гишүүнээс хасах; 3.8-д сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, шийтгэлийн төрөл, уг шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа, сахилгын шийтгэлгүйд тооцох зэргийг заасан байна.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г Үндсэн дүрмийн 6.5-д намын дарга нь Их хурлаас 4 жилийн хугацаатайгаар сонгогдох, түүний бүрэн эрхийг, мөн 6.6-д намын даргад нэр дэвших, сонгох, сонгогдох, чөлөөлөх, огцруулах талаар ерөнхийлөн зохицуулжээ.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д “намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг Үндсэн дүрмийн 9.2-т орлого бүрдүүлэх, төвлөрүүлэх; 9.3-т намын гишүүний татвар ба хандив; 9.8-т намын санхүүгийн тайланг хэлэлцэх журам; 9.9-т төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн талаар тус тус тусгасан байна.

Их эв намын Үндсэн дүрмийн 4.8.8.1, 4.8.9.1, 4.8.9.2 дахь заалтуудад “Намын төв хороо” гэж бичсэн байх боловч тус намын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/2512-2 дугаар албан бичгээр “... 2025 оны 11 дүгээр сарын 30-нд хуралдсан Их эв намын ээлжит бус III Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгаар 4.8.8.1 ба 4.8.9.1, 4.8.9.2 заалтуудад “намын Бага хурал” гэж бичигдсэн боловч 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан Ээлжит бус II Бага хурлаар шийдвэрлэсэн үндсэн дүрмийн шинэчилсэн найруулгад “намын Төв хороо” гэж бичсэн техникийн алдаа гарсан” гэх тайлбарыг ирүүлсэн тул тухайн заалтуудыг зөрчилгүй, засагдах боломжтой гэж үзлээ.

Иймээс, Их эв намын Үндсэн дүрэм нь бүхэлдээ хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцсэн байна.

Их эв намын Үндсэн дүрэм (Шинэчилсэн найруулга)-д товчилсон нэр хэрэглэхгүй гэснийг тэмдэглэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Их эв намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ